

НОМЫН ШҮҮМЖ

**ГОМБОЖАВЫН «ЧЖАНАГ ЧОЙЖУН» ХЭМЭЭХ НОМЫН
ТУХАЙ**

Баруун үзэмчин хошууны гүн Гомбожавын бичсэн энэхүү зохиолын хураангуй нэр нь «Чжанаг чойжун» («Хятадад буддын шашин дэлгэрсэн түүх») юм. Өгүүлэн буй энэ зохиол нь модон бар, гар бичмэл эхээрээ бидний үе хүрч ирсэн байна. Уул зохиол нь ХХ зууны үеэс эрдэмтэн мэргэдийн анхаарлыг татаж, судалгаа—шинжилгээний эргэлтэд орж эхэлсэн билээ. Гэвч уул зохиолыг өнөө хүртэл Өрнө, Дорнодод бүрэн гүйцэд судалж, бүрэн гүйцэд орчуулж, тайлбар зүүлт хийсэн үгүй байна. Ялангуяа уул зохиолыг утга судлал, эх бичиг судлал буюу түүх бичлэгийн талаас нь өөр бусад төсөөтэй зохиолтой харьцуулан судалсан судалгаа бүр ч ховор ажээ. Харин энэ дашрамд өгүүлэхэд Төвд хэлээр бичсэн Монголын түүхийг орчуулан судлах хэрэгт зөвлөлтийн эрдэмтэд их анхаарч жинтэй хувь нэмэр оруулж ирсэн, оруулсаар ч байна. Түүний дотроос эрдэмтэн Р. Е. Пубаев «Пагсан чжонсан» («памятник тибетской историографии XVIII в».)-г орчуулж, тайлбар зүүлттэйгээр 1984 онд хэвлүүлсэн нь бидний судалгааны ажилд ихээхэн тус дөхөм болж байна. Гүн Гомбожавын энэхүү зохиолыг бичсэн байдлыг нь ажиглан үзэхэд, «Чойгад» номын хэлээр голдуу бичсэнээс гадна бас зарим газар эгэл жирийн ард олны өгүүлэн ярьдаг «палгад» хар ярианы хэлээр бичсэн нь ажиглагдаж байна. Эл зохиолын төвд бүрэн эх нь гар бичмэлээр Гандантэгчилэн хийдийн номын санд байгаа бөгөөд 45х9 хэмжээний 135 хуудастай, бичмэл судар юм. Энэхүү гар бичмэл эхийг 50-иад оны үед бичсэн бололтой. Чухам хэн гэдэг хүн хуулан бичсэн нь одоогоор тодорхойгүй байна. Уг зохиолыг бүтцийн нь хувьд авч үзвэл: ерөнхий оршил, 3 бүлгээс бүтжээ. Ерөнхий оршилд орчлон ертөнцийн гарал үүсэл, тогтцыг сав болон шим ертөнц хэмээх ухагдуунд хамааруулсан, шашин философийн онолын үүднээс тайлбарлажээ. Жишээлбэл: «Үндэс бүгдийн хаан Цогт цагийн хүрдийн үндэс» (2 а) гэж бичээд Ш. Дамдин «Хуран үйлдэхүйн зүрхэн» («Донбий үйсүү яндаг жунди, ланцуй гоний үйсүү гонжийшин») гэж өгүүлжээ. (5 б талд). Үйсүү гэдэг нь «хоосны төвөөс» гэж орчуулагдах бөгөөд утга нь «дан», «ёо» гэсэн хоёр ухагдахуун юм. «Дан» нь үгчилбэл «бат», энэ нь сав ертөнц гэсэн утгатай. «Ёо» гэдэг нь үгчилбэл «хөдлөхгүй» гэсэн утгатай шим ертөнцийг төлөөлжээ. «Жунди» гэдгийг «үнэхээр гарах» гэж орчуулдаг бөгөөд утга нь уул, ус, газар дэлхий тэргүүтэн гэсэн үг юм. «Ланцуй» гэдэг нь тогтолцох гэсэн үг бөгөөд «да» гэдгийг үгчлэн орчуулбал «хийгээд» гэсэн үг юм. Түүний утга нь «хүмүүн нигууд» буюу хүн төрөлхтөн үүсч бий болсныг өгүүлсэн ажгуу. Энд өгүүлэн буй «гоний сүү гонжийшин» гэдэг нь үгчилбэл «өндөгний голоос өндөг төрөх мэт» гэж орчуулагдах бөгөөд өргөн утгаар «амьтан нигууд төрөн гарах» гэсэн санаа билээ.

Ер нь XVII, XVIII зууны үеийн монгол бичгийн хүмүүс Монгол, Төвд, Хятадын түүх зохиолдоо шашин—философийн «дүйнхор» («калачакратантры») хэмээх ертөнцийг үзэх үзлийн үүднээс ихэвчлэн бичдэг байсан байна. Тэд философи сэтгэлгээний үүднээс ертөнцийг танин мэдэхийг оролдхийлж байсан боловч нийт зохиолоо бичихдээ тухайн үеийн ангийн байр сууринаас авч тайлбарласан болох нь нэн тодорхой ажгуу. Ер нь тэдний бичсэн зохиол бүтээлийг уншиж үзэхэд дундад зууны үеийн түүх бичлэгийн хэвшмэл уламжлалт ёсыг чанд баримталсан нь нэн тодорхой ажиглагдаж байна. Гүн Гомбожавын хувьд бол тэрээр зохиолоо бичихдээ нэгэн тив, нэгэн улс гүрний хүрээнээс хальж, ертөнцийг бүхэлд нь сонирхон судлах замаар бичсэн нь түний мэдлэгийн хэм хэмжээг тодорхойлох жишээ юм. Тэрээр зохиолдоо «Замбуутив тивд (Азид—Д. Ц.) их, бага улс гүрэн зуу гаруй» (2 а) буй гэж бичээд, дэлхий ертөнцийн хамаг үзэгдлийг Ази тивээр жишин тайдбарлажээ. Ази тивд 100 гаруй улс орон оршин тогтнож байгааг Энэтхэг, Хятад, Төвд, Монгол тэргүүтэн 4 улсаар төлөөлүүлэн бичжээ. Гомбожав аливаа орны түүхийг бичихдээ, ертөнц дахины түүхийг бүхэл бүтэн нэгэн үзэгдэл гэж үзээд, Ази тивийн дотроос Хятадын түүхийг түүний зөвхөн нэгэн хэсэг болгон өгүүлжээ.

Тэрээр Ази тивийн 100 гаруй улс орон бол тус бүрдээ төртэй, эзэнтэй бөгөөд харин Энэтхэг, Хятад, Төвд, Монгол бол түүхэнд нэрд гарсан тодорхой эзэнт гүрнүүд юм гэж үзжээ. Зохиолч Хятадын шашин Философи, Феодалын нийгэм, улс төрийн системийн харилцаа болон ерөнхий түүхийг нь бичихдээ, Хятадтай хөрш орших улс орны хил хязгаарын асуудлыг хөндөн бичсэн нь түүхийн ихээхэн сонирхолтой, үнэ цэнэтэй баримт материал юм. Тухайлбал, түүний зохиолд Хятадын хил хязгаарын тухай бичихдээ, Хятадын хөрш орших улс орны хил хязгаарын асуудлыг хөндөн бичсэн нь түүхийн ихээхэн сонирхолтой, үнэ цэнэтэй баримт материал юм. Тухайлбал, түүний зохиолд хил хязгаарын тухай бичихдээ, «Хятад нь зүүн биен талаараа Шанхай хэмээхүй далайд тулах бөгөөд өмнө биен талаараа Ань-нан (Вьетнамд —Д. Ц.), умард баруун биен талаараа Урт цагаан хэрмээр чухамтай хүрээлэгдэнэ» (2 б) гэж өгүүлжээ.

Чухам ингэж Гомбожав нь өөрийнхөө зохиолд Хятад оронтой хил савласан улс орны хил хязгаарын цар хүрээ, зааг хэмжээг тодорхойлохдоо, газар ус уулын нэрээр нарийвчлан ялган зааглаж бичжээ. Энэ нь орчин үеийн судалгаа—шинжилгээний ажилд түүхийн үнэ цэнэтэй материал мөн. Нөгөө талаар Гомбожав нь зохиолдоо Хятадын нутгийг Цагаан хэрмээс дотогш байсныг олон талын иш үндэстэйгээр зааж нотлоод, Хятад орны ерөнхий байдал, физик—газар зүйн тойм болон хот суурин, тосгон гацаа, соёл иргэншлийн байдлыг дурьдаад тэрхүү нутагт оршин суух хүн амын тухай өгүүлжээ. Мөн Хятадын засаг захиргааг эдийн засгийн байдлаар нь авч үзээд, их муж 13, бага муж 3, бүгд их бага нийлсэн 16 муж болгон ангилж бичээд, Хятадад 5 өндөр уул, 4 сүмбэр оргил, явганаар гаталж болшгүй 4 их мөрөн, 5 том далай, хаад язгууртны 5 их ордон, 5 дунд ордон, 7 бага ордон байдаг гэжээ.

Бидний өгүүлэн буй зохиолын нэгдүгээр бүлэгт (3б—23а) Хятад орны ерөнхий байдал, тэргүүлэн суусан эзэн хаадын удам угсаа, язгуурын дарааллыг өгүүлжээ.

Хоёрдугаар бүлэгт (33а, 33б—86а) Хятад оронд бурхны шашин хэрхэн нэвтрэн дэлгэрсэн байдлыг өгүүлэхдээ, Монгол, Энэтхэг, Кашмир, Балба, Арслан тивийн улс (Шриланка), Төвд, Хотон, Уйгар зэрэг Төв Азийн улс орнуудын соёл иргэншил харилцан нөлөөлсөн байдлаар тодорхой жишээ дурьдан өгүүлжээ.

Гуравдугаар бүлэгт (85а—133а) Хятад оронд бурхны шашны гол ёс болох «хина яна» («бага хөлгөн»), «маха яна» («их хөлгөн»),

«Ваджра яна» («Очирт хөлгөн»), эдгээр гурван хөлгөн судар нэвтэрсэн арга зам, явц байдлыг өгүүлжээ.

Гүн Гомбожав зохиолынхоо нэгдүгээр бүлэгт Хятадын түүхийн товчийг бичихдээ, Хятадын хаадын домгийг үндэслэн 3 Хуан, 5 Ди, 3 Вангаас (16 а) эхлээд Фуси хааныг залгамжлан дамжсан 16 хаан, Шүн Нүнгийн 8 хаан (510 жил), Ши-я-гийн 27 хаан (441 жил), Шангын 28 хаан (644 жил), Баруун Чжоугийн 38 хаан (874 жил), бүгд 2975 жил, түүн дээр хожуу Чжоугийн 247 жил нэмэгдэж, бүгд 3222 жил бол м.э.ө Хятадын хаадын угсаа мөн гэжээ. Цааш нь Хятадын түүх гэдэг нь Их Сун улсын 9 хааны 167 жилийн хаанчлал (21 б) хойд Сун улсын хааны 153 жилийн хаанчлал (22 б, 23 а), их Тан улсын 20 хааны үеийн 289 жил (23 а), их Хан улсын 26 хааны 467 жил (20 а) буюу Цзинь улс, Юүгээр улсууд зэрэг маш олон төрийн улс болон Сүй улсын хаан төр мөн хэмээн өгүүлжээ. Чухам ингэж Гүн Гомбожавын зохиолд Хятадын хаадын хаан төр барьсан жил хугацааг маш нарийн тогтоожээ. Түүний бичсэнийг Хятадын хаадын он дарааллын бичигтэй тулгаж үзэхэд яг тохирч байна. Харин Юүгээр улс гэдэг нь Хятад Цзинь улсын суурин дээр байгуулагдсан Сун (м.э. 493), Ци (494—518), Лянь (518—568), Чэн (569—589) зэрэг улсуудын төр хаадыг хэлсэн бололтой. Эдгээр улсуудыг залгаж Хятадын Суй улс 589 онд тогтсон билээ. Өөрөөр хэлбэл манай эриний 265 он Хятадын язгуур улс Цзинь улс байгуулагдсанаас эхлэн Хятадын их нэгдлийг бий болгосон Суй улс мөхсөн 618 он хүртэл бүгд 353 жил байсан бөгөөд энэ нь Гомбожавын бичсэнтэй яг нийлж байна.

Зохиогч нь өөрийнхөө зохиолд Хятад орныг тэргүүлэн суусан эзэн хаадын удам дарааллыг олон зуун жилийн үеийг хамруулан авч бичээд, тухайн үеийн Хятадын хаан төрүүдийн нийгэм—улс төрийн амьдралыг товчоор тоочин өгүүлж, Хятад оронд хууль цааз тогтоож байсан байдал, үсэг бичиг үүсгэн хэрэглэж байсныг нэлээд чамбай баримтад тулгуурлан өгүүлсэн нь үзэгдэнэ. Мөн эм засал (эмнэлэг)-ын ухаан, од гариг судлал буюу одон орны судлал, зурхай тооны ухаан (хар зурхай)-ыг хэрхэн хөгжүүлж байсан тухай сонирхолтой мэдээ дурьджээ. Зохиогч эл зохиолынхоо (23 а, 27 б) талд монгол хаадын тухай өгүүлж Чингисээс Лигдан хутагт хаан хүртэл 429 жилд их, бага бүгд 35 хаан Монгол улсын хаан ширээнд ээлжлэн сууж төр барив гэж бичжээ. Гүн Гомбожав нь хэдийгээр Хятадын түүх дотор оруулан Монгол хаадын тухай бичсэн боловч Хятадын эзэн хаадын угсаа гарлын дотор Монголын хаадыг оруулж бичээгүй, тусгаар улсын хаадын байдлаар тусгай зүйл болгон бичсэн байна. Тэр ч байтугай Монголын түүхийн талаар баримталж байсан Хятадын их гүрний дээрэнгүй «хятад төвийн» үзлийг шүүмжилсэн утга санаа бүхий зүйл түүний зохиолд нилээд газар гарч байна. Юан гүрнийг монголчууд үндэслэн байгуулж, хятадын төрийг барьж байсан болохоор тухайн үеийн монгол хаадыг зохиогч заавал тоочин өгүүлэх шаардлагатай болсон байж болох юм.

Ер нь ХҮII, ХҮIII зууны үед бичигдсэн Монголын түүхийн зонхилох зохиолыг ажаад үзсэн ч Энэтхэг, Хятад, Төвд, Монгол 4 орноор тэргүүлэн бичсэн байдаг. Энэ нь эдгээр улс орныг Азийн 4 том улс гээд, харилцан эрх тэгш, биеэ даасан бүрэн бүтэн нэг нэг улс гүрэн гэж үздэг байсных юм. Үнэндээ орчуулж судалсан миний хувьд бол Монголын түүхийн талаар бичсэн энэ хэсгийн зарим нэг газар шүүмжлэлтэй хандах мэр сэр зүйл байвч тэр нь уул зохиолын үнэ цэнийг бууруулж байгаа хэрэг огт биш бөгөөд гүн Гомбожав чухам ямар нийгэмд, ямар үед амьдарч байхдаа эл зохиолоо бичсэн бэ гэдгийг эрх биш анхаарах нь бас ч илүүдэхгүй бизээ.

Эл зохиолын «Шашин бодитой дэлгэрсэн ёс» хэмээх хоёрдугаар бүлгийн гол агуулга нь цэвэр шашны холбогдолтой юм. Гэхдээ Хятадад буддын шашин дэлгэрсэн тухай, тухайн үед буддын шашинтай бөө мөргөл тэмцэлдэж байсан зэрэг сонирхолтой шинэ соргог мэдээ гарч байна. Хятадад үүсэн гарч оршин тогтнож «таалал адил бус гурван ёс» гэдэг нь буддын ёс, бөөгийн ёс, шү-дэнгийн ёс (зурхайн ёс)-ыг өгүүлж байгаа ажээ.

Хятадын баруун Хан улсын XIV хаан Мэн ди (м. э. 58--76)-ийн 58 он буюу төмөр хулгана жил эзэн хаан ширээндээ суугаад нэгэн жил болсны дараа Хятадад буддын шашин дэлгэрүүлэхийн тул санваартан хувраг хүн залж авчруулахаар Энэтхэг оронд элч илгээжээ (34 а). Энэ тухай Гомбожав бичихдээ, яг тэр үед «Энэтхэгээс Одсүрэнгийн угсааны Архат (дайсныг дарагч) Маданга бандида фхалан нар цагаан моринд бурхны хөрөг, судар нижгээдийг ачаад Хятадын зүг явжээ. Ийнхүү хоёр элч замд уулзаж, хамтаар Хятадад ирэв» гэжээ (34 б). Үүнээс үзэхэд Хятад оронд буддын шашин дэлгэрсэн жил гэвэл хан улсын Мэн Ди хаан ширээнд суусан 8-р он буюу гал хонин жил өөрөөр хэлбэл Будда таалал төгссөн—гал туулай жилээс хойш 940 жил өнгөрсний дараах гал хонин жил буюу Буддагийн тогтоон соёрхсон (иш үзүүлсэн) төмөр луу жилээс эхлэн тоолбол 947 жил өнгөрсний дараах үйл явдал ажээ. Хятад судар бичигт тэмдэглэснээр бол модон бар жилд Будда мэндэлж 79 настайдаа усан мичин жил таалал төгссөн гэж үздэг юм. Хятадын энэ баримтлалаар бол буддын шашин Хятадад дэлгэрсэн жил нь буддагаас 1050 жилийн дараах хэрэг явдал болж байна. Гэтэл энэ бол гүйцэд зөв үндэслэлтэй зүйл биш мэт санагдана.

Харин гал хонин жил буддын шашин Хятад оронд лавтай дэлгэрсэн тухай бодитой мэдээ материал их дайралдах билээ. Энэтхэг орноос гурван шүтээн (трипитка-г хэлж буй Д. Ц.)-ийг урин залж, эргэл хүндэтгэл зохиож, дуган сүм бариулан, бага, их хөлгөн судар орчуулах болжээ. Хятадад буддын шашин бодтой дэлгэрч эхэлсэн үе бол Хан улсын Минди хааны 8-р он буюу м. э 65 он мөн болох нь нэгэнтээ батлагдаж байгаа билээ. Гомбожав өөрийн зохиолдоо Хятад оронд шашин дэлгэрэх болсон шалтгаан, анх чухам яаж хэдийд нэвтрэн дэлгэрч эхэлсэн, түүний түүхэн нөхцөл болон Хятад—Энэтхэгийн худалдаа, соёлын харилцааны тухай сонирхолтой мэдээнүүдийг дэвшүүлэн тавьсан боловч зарим газар төдий л үнэмшилтэй биш болсон юм уу гэмээр байна. Зөвхөн домог яриа, хааны зүүд мэтийг иш татан бичиж, түүхийн сурвалж материалд бага тулгуурласан нь ажиглагдаж байна. Тухайлбал Хятадын хаан төрийн бодлогод буддын шашны хүч нөлөөг хүчтэй болгох зорилго, аргын үүднээс Хятадад буддын шашин дэлгэрэхийг нэгэнт будда өөрөө соёрхож уг үйл явдал бурхны тааллаар аяндаа буй болсон мэтээр сурталчлахын тулд домог яриа, хааны зүүд зэргийг Хятадад их ашиглаж ирсэн уламжлалыг гүн Гомбожав авч хэрэглэжээ. Тухайн тэр үед Энэтхэг, Хятад хоёр улсад худалдааны өргөн зам харилцаа нээгдсэн байв. Хан улсын У Ди (м. э. ө. 140—м. ө. 87) хааны үед Хятадаас баруун зүг Төв Азийн орнуудад нэвтрэх зам харилцаа нээгдсэн ажээ. Түүхэнд үүнийг торгоны зам гэж нэрлэдэг билээ. Мөн Энэтхэгээс Хятад оронд нэвтрэн ирэх нь нэгэн адил их болж, энэ нь Хятадад шашин дэлгэрэх явдалд маш их рольтой болжээ. Эхлээд Энэтхэг, Хятадын хоорондын худалдааны харилцааны зам байсан тэр газар орон нь яван явсаар ийнхүү шашин, соёлын харилцаа болон өргөжжээ. Тэр үед Дорно дахины эртний соёлт хоёр улс (Хятад, Энэт-

хэг)-ын харилцаа нэлээд өргөн хэлхээ холбоотой болохыг буддын шашин авахаар явсан Хятадын элч болон буддын шашин дэлгэрүүлэхээр Энэтхэгээс Хятадад очсон Маданга бандида Фхалан нарын үйл явдлаас тодорхой байна. Тэдгээр элч Хятадад ирсний дараа бөө мөргөлийн ном судар олныг шатааж, Хятадын зүгээс буддын шашныг нэгэнт тийнхүү хүчээр дэлгэрүүлсэн учир арга буюу буддын шашны хүч давамгайлж, бөө мөргөлийг ялав гэх мэтээр Гомбожав бичжээ. (34 а). Хятадын хаан төр буддын шашныг Энэтхэгээс хүлээн авснаар төрийн шашин болгов гэсэн энэхүү мэдээг цаашид улам нарийвчлан судлах шаардлагатай юм. Яагаад гэвэл тухайн үед Хятадад маш их нөлөөтэй давамгайлж байсан Кунзын сургаал, бомбын шашныг буддын шашин тийм хоромхон зуур ялж дийлээд төрийн зонхилох шашин болсон гэхэд үнэмшил багатай шашны судар сургаалыг өөрийн зэргэлдээ улс оронд номлож, буддын шашныг үзэл суртлын зэвсэг болгон ашиглах зорилготой байсан баримт нотолгоо элбэг байгаа нь бүр сонирхолтой юм. Гомбожав Хятадын буддын шашны түүхийг доорх гурван зүйлд ангилан хувааж бичжээ. Үүнд: Хятадад буддын шашин дэлгэрэх явдалд Энэтхэг болон Төв Азийн бандида орчуулагч нарын гүйцэтгэсэн үүрэг, Хятадын хуушаан (фа-сянь) нарын үйл ажиллагаа болон Хятадад байдаг гурван сав судрын аймагт хамаарагдах номын нэр тоог тоочин бичжээ.

Хятад оронд буддын шашин дэлгэрүүлэх, буддын шашны судар номыг орчуулах явдалд Энэтхэгийн бандида (таван ухаанд мэргэжсэн) нэр болон орчуулагчид (лозваа) нарын гүйцэтгэсэн үүрэг гол зонхилох рольтой болох нь илэрхий юм. Тэд Хятад оронд байхдаа буддын шашны гурван сав аймгийн судар болох Номхотгууны аймгийн үндэслэл, Нууц тарний үндэслэл, Дундач үзэл (Нагаржуна), Агуу их явдлын аймгийн судрын үндэс (Асанга) зэргийг Хятадаар орчуулах ажил хийсэн байна. Хятадад дэлгэрсэн буддын шашны ном судрыг «гүн нарийн үзлийн үндэсний хэсэг», «агуу их үйл явдлын үндэсний хэсэг» гэж хоёр үндсэн ангид хуваадаг.

Гүн нарийн үзлийн томоохон төлөөлөгчид бол м. э. ө. 212—м. э. 914 оны эрдэмтэд Донбо, Жамьян, Нагаржуна, ловон Тинмигжан (м. э. 320—400), Тансан (600—664) нар болно.

Агууа их явдлын үндэсний төлөөлөгчид бол Буддха, Майдар, Асанга (б6 т6 310—390), Паратарта (?—589) нар болно. Энэтхэгийн шашин, соёл Хятадад ийнхүү гүнзгий нэвтэрч, хятадын хуушаан, жуулчид нар Энэтхэгээс буддын судар номыг судлах болжээ. Тэдний томоохон төлөөлөгчдийн нэг бол манай эриний 343 буюу 344 оны үед төрсөн Энэтхэгийн Кумаражива юм. Тэрээр Энэтхэгийн Куча хааны үед төрсөн ажээ. Хятадын Баруун Цзинь (265—317)-д буддын шашин нэлээд хүчтэй нөлөө үзүүлж байсан мэдээ байна.

Гомбожавын «Хятад оронд буддын шашин дэлгэрсэн түүх»-ийн Тансан ламын тухай өгүүлсэн хэсэгт «Тансан лам (сюань-цзан) бол их Хан улсын ноён Жүн-гүний удам угсаа бөгөөд тэрээр умар зүгийн Турфан (Гао-чан), дунхуан орноор очихдоо Турфан» Гао-чангийн) хаантай урьд таньдаг худалдаачнаар дамжуулан уулзаж буддын шашны билэг брамидын зарим судрыг сурталчилан, тахилын орон болгожээ.

Гао Чангийн хаан Тансан ламд алт 100 лан, 24 орноор өнгөрөх замын бичиг хайрлаад, улмаар уйгарын хаанд явуулан бараалхуулжээ (67 тал). Түжэвэй Уйгарын хаан Ихү-Хохон Тансан ламд (сюань Цзан) хүндлэл үйлдээд, түүнийг Тэмүн (төмөр хаалга хүргэжээ. (67 б)

Тансан лам—Сюань цзан бол тухайн үедээ буддизмын номнол сургаалыг гүн итгэн, түүний ёсыг дагахад биш, тэдгээр улс орны амьдралын тал бүрийг сонирхон судалж, улмаар Энэтхэгт очиж ихээхэн нууц ажиглалт хийж тэмдэглэл хөтөлсөн хүн юм. Энэ нь Хятадын тухайн үеийн эзэрхэг төрийн хаадаас буддын шашныг төрийн хэрэгтээ сүрхий овжин ашиглан, хөрш бусад улс оронд өөрийн үзэл бодлыг буддын шашны далбааны дор сурталчилж, улмаар тэдгээрийг өөртөө хавсарган нэгтгэж хятадчилах гэсэн бодлого явуулж байсны илрэл мөн гэж үзэж болмоор байна.

«Хятад оронд дэлгэрсэн буддын шашин ном судрын мэдээ» хэмээх гуравдугаар бүлэгт тэр үед орчуулж байсан ном судрын тухай нэлээд өргөн асуудлыг хамарч дэлгэрэнгүй бичжээ. Тэр бүхнийг энэ удаагийн өгүүлэлд бүрэн гаргаж бичих боломжгүй байна. Зөвхөн уул бүлгийг товч хураангуйгаар өгүүлбэл, тэр цагт Хятадад 663 жилд 176 орчуулгач 1507 ном орчуулсан бөгөөд дараа нь Манжийн хаанчлалын үед 242 ном нэмэн орчуулжээ. Нийтдээ 10 зууны туршид бүгд 4700 боть ном орчуулсан байна.

Энэхүү өгүүлэлд Гомбожавын «Хятад оронд буддын шашин дэлгэрсэн түүх» гэдэг номын бүхэл асуудлыг бүрэн хамааран өгүүлж болохгүй нь мэдээж юм. Гомбожавын түүх бичлэгийн үзэл онолын талын зөвхөн зарим асуудлыг авч үзэхийг хичээсэн билээ.

Гүн Гомбожав бол тухайн үедээ нэлээд боловсролтой, гадаадын 4 (манж, хятад, санскрит, төвд) хэлтэй хүн байжээ. Ийнхүү XVII зууны сүүл XVIII зууны эхэн үед амьдарч байсан монгол хүн Хятадын төр шашны түүхийг судлан бичсэн явдал бол тухайн үеийн монголчуудын мэдлэг, ухаан, түүх, соёлын хэмжээг судалж мэдэх нэгэн талын баримт мөн бөгөөд Хятадын түүх судлалд гүн Гомбожав зохих хувь нэмэр оруулжээ.

Зохиогч энэ бүтээлдээ Энэтхэг, Хятад, Монголын эртний үеийн улс төр, шашин, соёлын харилцааны талаар нэлээд анхаарч уул асуудлын талаар сонин санал, дүгнэлт хийж шийдвэрлэхийг хичээсэн нь бүр их ач холбогдолтой юм. Гомбожав уг зохиолынхоо бүлгүүдийн төгсгөл хэсэг бүрт товч дүгнэлт хийсэн байна.

Эцэст нь дүгнэхэд, гүн Гомбожавын зохиол нь хэдийгээр шашны үзэл санаагаар дүгнэж бичсэн тал байвч түүхийн ховор нандин материал ашиглаж, монгол хүний үзэл санаагаар сэтгэн, аливаа асуудалд хандаж, Хятадын түүхийн материалд сохроор хөтлөгдсөнгүй, харин түүнийг нэлээд ул үндэстэйгээр боловсруулан дүгнэх замаар зохиолоо бичжээ. Гомбожав бол Хятадын түүх бичлэгт тодорхой хувь нэмэр оруулсан монгол эрдэмтэн хүн бөгөөд энэ хүний зохиол бүтээлийг хойшид улам нарийвчлан судлах шаардлагатай гэж үзнэ.

Д. Цэдэв

О КНИГЕ ГОМБОЖАВА «ЧЖАНАГ ЧОЙЖУН»

(Резюме)

Это произведение Гомбожава из хошуна западных узэмчинов (ныне Внутренней Монголии) носит краткое название «Чжанаг чойжун» («История буддизма в Китае»). Произведение состоит из введения и дается религиозно-философское объяснение 3-х глав. Во введении происхождению и становлению Вселенной как органического, так и органического мира. Автор считает: «Материк Замбуу» (Азия —Д. Ц.), являясь некой частью Вселенной, включает в себя более 100 больших и малых стран». Описание Азии и её стран согласно традициям начинается с Индии, Китая, Тибета и Монголии. Гомбожав, описывая историю какой-либо страны, рассматривает историю Вселенной как единой целой. Он считает, что страны Азии, в том числе Индия, Китай, Тибет и Монголия являются самостоятельными государствами королевств.

В первой главе данного произведения пишется о положении Китае, о генеологии его правителей. Главное содержание 2-ой главы произведения, где говорится «О закономерностях реального распространения религии», связано, с чисто религиозной проблематикой. В то же время здесь имеются новые интересные сведения о распространении буддистской религии в Китае, о её борьбе с шаманизмом на своём пути распространения.

В 3-ей главе рассказывается о распространении религиозных сутр будды в Китае, в частности о процессах и путях проникновения священных книг трипитаки. В данной статье рассмотрены структура, содержание и основные идеи работы монгольского историографа ХУШ в. Гомбожава «История буддизма в Китае».

В заключении статьи автор подчеркивает, что данная книга Гомбожава представляет ценным историческим материалом, имеющим определенное значение для изучения истории Китая и других стран Азии.